

НИСЛЭГИЙН ЖУРАМ БОЛОВСРУУЛАЛТЫН АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН  
ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЙЛАН  
ТОВЧЛОЛ/

2019.05.31

Улаанбаатар хот

ИНЕГ-ын даргын 2019 оны 05 дугаар сарын 20-ны өдөр баталсан ИНЕГ-ын харьяа НЖБА-ны үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай удирдамжийн хүрээнд тус нэгжийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ны ахлах аудитор Л.Жаргалсайхан, менежер П.Батсайхан, санхүүгийн хяналтын мэргэжилтэн Б.Болормаа, Ц.Цацрал нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2019 оны 05 дугаар сарын 21-ний өдрөөс 2019 оны 05 дугаар сарын 28-ны өдрийг хүртэлх хугацаанд дотоод аудитыг хийсэн.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд НЖБА-ны 2018 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацааны захиргаа, хүний нөөцийн үйл ажиллагаа, үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журам болон дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, үр дүнгийн гэрээний болон төсөв төлөвлөгөөний гүйцэтгэл, цалин хөлсний бодолт, олголт зэргийг үндсэн баримт нотолгоонд тулгуурлан шалгах, зарим эргэлзээтэй зүйлүүд дээр холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга аван ажиллалаа.

ИНЕГ-ын даргатай байгуулсан 2018 оны үр дүнгийн гэрээний хэрэгжилт 87.4 оноогоор В буюу "Сайн" үнэлгээтэй дүгнэгдсэн.

БНХАУ-ын Бээжин хотын Капитал олон улсын нисэх буудлын нислэгийн төвөөс зохион байгуулсан сургалтад шалгалтын нислэгийн хэсгийн 15 шаллагч инженерийг хамруулж, туршлага судалжээ.

Архив, албан бичиг хэргийн хөтлөлтийг заавар, журмын дагуу сайн хийж гүйцэтгэсэн, үдэлт, цэгцлэлт хангалттай түвшинд байна.

Хөдөлмөрийн гэрээнд нэмэлт өөрчлөлтийг тухай бүр хийгээгүй.

Ажлын цагийн бүртгэлийг буруу гаргасан.

НЖБА-ны 2018 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 08/Г/55 дугаар албан бичгийн хариу болгож ИНЕГ-ын ЗУГ-ын 2018 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 04/1121 дүгээр албан тоотоор ...Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2012 оны А/385 дугаар тушаалаар батлагдсан "Тухайн мэргэшлээр мэргэшсэн байх шаардлагатай албан тушаалын жагсаалт"-д тус албаны дарга, менежер, шалгалтын нислэгийн хэсгийн дарга гэсэн албан тушаал байхгүй байх тул мэргэжлийн зэргийн нэмэгдэл олгох боломжгүйг үүгээр мэдэгдье... гэсэн хариу ирүүлсэн байхад албаны менежер Г.Энэбишид өнөөг хүртэл үндсэн цалингийн 10 хувиар тооцож зэргийн нэмэгдэл олгож байсан.

Цалинтай чөлөөг ажилласан хоногт оруулж тооцсоноос хоолны үнийн хөнгөлөлт илүү олгосон.

2018 оны ДАА-ны дүгнэлтийн хэрэгжилт, НААХЗД-ны байцаагчийн 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дүгнэлтийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, 2019 оны ДАА-ны аудитын үеэр илэрсэн асуудлуудыг дүгнэж үзэхэд тухайн нислэгийн журам зохиолтод аюулгүй ажиллагааны үнэлгээ хийх зөвлөл /баг/ байгуулах шаардлагатай байна.

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлын засаж, залруулах талаар тус албанд нийт 8 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА